



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/8/СТА-ТШЗ**

|  |   |
|--|---|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Чойбалсан хот<br>2021 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга<br>бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203<br>Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207<br>Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Аудитор: Э.Нандинчимэг<br>Утас: 7000-3775<br>Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| ДОА      | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар                      |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                                 |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                       |
| МУЕА     | Монгол Улсын Ерөнхий аудитор                                |
| ДОА      | Дорнод аймаг  |
| ЗТХС     | Зам тээвэр, хөгжлийн сайд                                   |



## Агуулга

|  |    |
|--|----|
| 1. Төрийн аудитын санал, дүгнэлт .....                           | 3  |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....                          | 5  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                 | 5  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....              | 6  |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                  | 7  |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....   | 8  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....               | 8  |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....               | 9  |
| 3. Аудитын тайлан .....  | 10 |
| 3.1. Ерөнхий зүйл .....  | 10 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....   | 10 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... | 10 |
| 3.4. Материаллаг байдал .....                                    | 10 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....                     | 11 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....       | 11 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл .....                                 | 12 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                            | 12 |
| 3.9. Аудитын илрүүлэлт .....                                     | 12 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....  | 12 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....               | 14 |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021. 02. 25 № 309

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ДОРНОД АЙМГИЙН ХӨЛӨНБУЙР  
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
М.БАЯРМАГНАЙ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 85 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020300

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>35,502,733.04</b>    | <b>40,926,745.20</b>    |
| 33         | АВЛАГА  | 153,248.34              | 573,434.00              |
| 33100      | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 153,248.34              | 573,434.00              |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | <b>35,349,484.70</b>    | <b>40,353,311.20</b>    |
| 351        | Түүхий эд материал  | 73,400.00               | 1,122,900.00            |
| 35130      | Эм боох материал  | 73,400.00               | 1,122,900.00            |
| 354        | Хангамжийн материал   | 35,276,084.70           | 39,230,411.20           |
| 35410      | Бичиг хэргийн материал  | 3,690,126.70            | 4,243,126.70            |
| 35420      | Аж ахуйн материал   | 29,493,023.00           | 31,071,465.50           |
| 35460      | Хүнсний материал  | 70,410.00               | 1,893,294.00            |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 2,022,525.00            | 2,022,525.00            |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>1,228,520,413.21</b> | <b>1,232,485,484.10</b> |
| 39         | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 1,228,520,413.21        | 1,232,485,484.10        |
| 392        | Биет хөрөнгө  | 1,223,077,413.21        | 1,227,195,484.10        |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 1,242,788,409.12        | 1,277,008,953.12        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | (49,459,117.98)         | (74,541,569.64)         |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 30,467,165.00           | 35,388,300.00           |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | (16,331,703.23)         | (21,683,251.09)         |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 24,271,162.00           | 26,252,134.50           |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | (21,509,875.22)         | (23,511,956.35)         |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 36,245,000.00           | 36,245,000.00           |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | (23,393,626.48)         | (27,962,126.44)         |
| 393        | Биет бус хөрөнгө  | 5,443,000.00            | 5,290,000.00            |
| 39301      | Програм хангамж   | 765,000.00              | 765,000.00              |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл   | (306,000.00)            | (459,000.00)            |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 4,984,000.00            | 4,984,000.00            |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>                                    | <b>1,264,023,146.25</b> | <b>1,273,412,229.30</b> |
| <b>4</b>   | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b>-</b>                | <b>573,434.00</b>       |
| 41         | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР   | -                       | 573,434.00              |
| 413        | Өглөг   | -                       | 573,434.00              |
| 4136       | Бусад өглөг   | -                       | 573,434.00              |
| 41362      | Хувь хүмүүст төлөх өглөг  | -                       | 573,434.00              |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>1,264,023,146.25</b> | <b>1,272,838,795.30</b> |
| 51         | Засгийн газрын хувь оролцоо   | 1,264,023,146.25        | 1,272,838,795.30        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 81,346,141.00           | 81,346,141.00           |
| 51101      | Өмч: - төрийн   | 81,346,141.00           | 81,346,141.00           |
| 512        | Хуримтлагдсан үр дүн  | 1,120,095,757.49        | 1,128,911,406.54        |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | 1,120,095,757.49        | 1,120,095,757.49        |
| 51220      | Тайланг үеийн үр дүн  | -                       | 8,815,649.05            |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 62,581,247.76           | 62,581,247.76           |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>                    | <b>1,264,023,146.25</b> | <b>1,273,412,229.30</b> |



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл    | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|------------------------|-----------------------|
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>   | <b>214,224,000.00</b>  | <b>340,598,636.00</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>2,180,000.00</b>    | <b>41,178,294.00</b>  |
| 120        | Нийтлэг татварын бус орлого  | 2,180,000.00           | 41,178,294.00         |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 2,180,000.00           | 41,178,294.00         |
| 1200045    | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | 2,180,000.00           | 41,178,294.00         |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>212,044,000.00</b>  | <b>299,420,342.00</b> |
| 1310       | Улсын төвлөрсөн төсвөөс  | 210,244,000.00         | 270,566,142.00        |
| 131007     | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих   | 210,244,000.00         | 270,566,142.00        |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого  | 1,800,000.00           | 1,640,000.00          |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,800,000.00           | 1,640,000.00          |
| 1320       | Орон нутгийн төсвөөс санхүүжих   | -                      | 27,214,200.00         |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | -                      | 27,214,200.00         |
| 2          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>276,411,417.06</b>  | <b>331,782,986.95</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>276,411,417.06</b>  | <b>331,782,986.95</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>276,409,839.06</b>  | <b>311,077,215.05</b> |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил  | 150,168,483.36         | 197,364,656.51        |
| 210101     | Үндсэн цалин   | 150,168,483.36         | 197,364,656.51        |
| 2102       | Ажлал олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл  | 19,567,682.79          | 25,992,753.54         |
| 210201     | Тэтгэврийн даатгал   | 13,562,827.87          | 18,037,912.48         |
| 210202     | Тэтгэмжийн даатгал   | 1,594,330.22           | 2,106,664.61          |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал  | 1,237,064.17           | 1,611,411.69          |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал   | 288,496.41             | 385,160.43            |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал  | 2,884,964.12           | 3,851,604.34          |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал  | 25,859,532.00          | 25,668,700.40         |
| 210301     | Гэрэл, цахилгаан   | 4,413,925.00           | 3,611,200.40          |
| 210302     | Түлш, халаалт  | 19,777,907.00          | 21,476,800.00         |
| 210303     | Цэвэр, бохир ус  | 1,667,700.00           | 580,700.00            |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал   | 2,043,650.00           | 5,767,400.00          |
| 210401     | Бичиг хэрэг  | 537,000.00             | 924,900.00            |
| 210402     | Тээвэр, шатахуун   | 657,600.00             | 650,000.00            |
| 210403     | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 426,800.00             | 1,396,800.00          |
| 210404     | Ном, хэвлэл  | 60,600.00              | 172,000.00            |
| 210406     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 361,650.00             | 2,623,700.00          |
| 2105       | Нормативт зардал   | 35,785,710.00          | 15,970,224.00         |
| 210501     | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл  | 200,000.00             | 50,500.00             |
| 210502     | Хоол, хунс   | 35,019,710.00          | 15,808,724.00         |
| 210503     | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 566,000.00             | 111,000.00            |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал  | 3,521,410.00           | 1,000,000.00          |
| 210604     | Урсгал засвар  | 3,521,410.00           | 1,000,000.00          |
| 2107       | Томилголт, зочны зардал  | 300,600.00             | 800,000.00            |
| 210702     | Догоод албан томилголт   | 300,600.00             | 800,000.00            |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажлал, үйлчилгээний төлбөр, хураамж  | 2,210,000.00           | 296,900.00            |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 2,030,000.00           | 116,900.00            |
| 210802     | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох   | 180,000.00             | 180,000.00            |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал  | 36,952,770.91          | 38,216,580.61         |
| 210902     | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | -                      | 1,059,000.00          |
| 210903     | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол   | 36,952,770.91          | 37,157,580.61         |
| 213        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>1,578.00</b>        | <b>20,705,771.90</b>  |
| 2133       | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг  | 1,578.00               | 20,705,771.90         |
| 213303     | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 1,578.00               | 20,705,771.90         |
| 3          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>  | <b>(62,187,417.06)</b> | <b>8,815,649.05</b>   |
| 4          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>  | <b>-</b>               | <b>-</b>              |
| 5          | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>   | <b>(62,187,417.06)</b> | <b>8,815,649.05</b>   |



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>  | <b>208,069,900.00</b> | <b>299,420,342.00</b> |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>208,069,900.00</b> | <b>299,420,342.00</b> |
| 1310       | Улсын төвлөрсөн төсвөөс  | 203,657,000.00        | 270,566,142.00        |
| 131007     | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих   | 203,657,000.00        | 270,566,142.00        |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>4,412,900.00</b>   | <b>1,640,000.00</b>   |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,092,900.00          | 1,640,000.00          |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 320,000.00            | -                     |
| 1320       | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | <b>-</b>              | <b>27,214,200.00</b>  |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | -                     | 27,214,200.00         |
| 2          | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>   | <b>205,769,900.00</b> | <b>299,420,342.00</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>205,769,900.00</b> | <b>299,420,342.00</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>205,577,566.70</b> | <b>278,714,570.10</b> |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | <b>127,747,699.01</b> | <b>198,395,161.70</b> |
| 210101     | Үндсэн цалин   | 89,833,899.01         | 143,285,100.00        |
| 210102     | Нэмэгдэл   | 17,772,000.00         | 40,894,252.63         |
| 210104     | Урамшуулал   | 11,217,000.00         | 14,215,809.07         |
| 210105     | Гэрээт ажлын хөлс  | 8,924,800.00          | -                     |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | <b>15,085,099.69</b>  | <b>24,809,000.00</b>  |
| 210201     | Тэтгэврийн даатгал   | 10,056,899.69         | 16,870,200.00         |
| 210202     | Тэтгэмжийн даатгал   | 1,257,300.00          | 1,984,700.00          |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал  | 1,005,400.00          | 1,587,800.00          |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал   | 251,500.00            | 396,900.00            |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал  | 2,514,200.00          | 3,969,400.00          |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | <b>19,310,158.00</b>  | <b>25,668,700.40</b>  |
| 210301     | Гэрэл, цахилгаан   | 5,029,801.00          | 3,611,200.40          |
| 210302     | Түлш, халаалт  | 14,220,357.00         | 21,476,800.00         |
| 210303     | Цэвэр, бохир ус  | 60,000.00             | 580,700.00            |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>2,409,610.00</b>   | <b>7,413,200.00</b>   |
| 210401     | Бичиг хэрэг  | 617,700.00            | 1,149,900.00          |
| 210402     | Тээвэр, патахуун   | 339,400.00            | 650,000.00            |
| 210403     | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 455,000.00            | 1,296,800.00          |
| 210404     | Ном, хэвлэл  | 270,000.00            | 300,000.00            |
| 210406     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, акуйн эд зүйлс  | 727,510.00            | 4,016,500.00          |
| 2105       | <b>Нормативт зардал</b>  | <b>38,993,500.00</b>  | <b>19,381,608.00</b>  |
| 210501     | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл  | 99,500.00             | 1,750,000.00          |
| 210502     | Хоол, хүнс   | 38,894,000.00         | 17,631,608.00         |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | <b>1,000,000.00</b>   | <b>1,000,000.00</b>   |
| 210604     | Урсгал засвар  | 1,000,000.00          | 1,000,000.00          |
| 2107       | <b>Томилголт, зочны зардал</b>   | <b>208,000.00</b>     | <b>800,000.00</b>     |
| 210702     | Дотоод албан томилголт   | 208,000.00            | 800,000.00            |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>-</b>              | <b>296,900.00</b>     |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | -                     | 116,900.00            |
| 210802     | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох   | -                     | 180,000.00            |
| 2109       | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>823,500.00</b>     | <b>950,000.00</b>     |
| 210902     | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 823,500.00            | 950,000.00            |
| 213        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>192,333.30</b>     | <b>20,705,771.90</b>  |
| 2133       | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>   | <b>192,333.30</b>     | <b>20,705,771.90</b>  |
| 213303     | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 192,333.30            | 20,705,771.90         |
| 3          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>  | <b>2,300,000.00</b>   | <b>-</b>              |
| 8          | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>   | <b>2,300,000.00</b>   | <b>-</b>              |
| 9          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   | -                     | 0.00                  |
| 10         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | 2,300,000.00          | -                     |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн       | Бусад       | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------------|-------------|--|
| <b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>       | 81,346,141.00                   | 62,581,247.76         | 1,120,095,757.49        | 0.00        | 1,264,023,146.25                       |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       |                                 |                       |                         |             | 0.00                                   |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>81,346,141.00</b>            | <b>62,581,247.76</b>  | <b>1,120,095,757.49</b> | <b>0.00</b> | <b>1,264,023,146.25</b>                |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт          |                                 |                       |                         |             | 0.00                                   |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт        |                                 |                       |                         |             | 0.00                                   |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    |                                 |                       |                         |             | 0.00                                   |
| Тайлант үеийн үр дүн                             |                                 |                       |                         |             | 0.00                                   |
| <b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>81,346,141.00</b>            | <b>62,581,247.76</b>  | <b>1,120,095,757.49</b> | <b>0.00</b> | <b>1,264,023,146.25</b>                |
| <b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>       | <b>81,346,141.00</b>            | <b>62,581,247.76</b>  | <b>1,120,095,757.49</b> | <b>0.00</b> | <b>1,264,023,146.25</b>                |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 0.00                            | 0.00                  | 0.00                    | 0.00        | 0.00                                   |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>81,346,141.00</b>            | <b>62,581,247.76</b>  | <b>1,120,095,757.49</b> | <b>0.00</b> | <b>1,264,023,146.25</b>                |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00                            | 0.00                  | 0.00                    | 0.00        | 0.00                                   |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | 0.00                            | 0.00                  | 0.00                    | 0.00        | 0.00                                   |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 0.00                            | 0.00                  | 0.00                    | 0.00        | 0.00                                   |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | 0.00                            | 0.00                  | 0.00                    | 0.00        | 0.00                                   |
| Тайлант үеийн үр дүн                             | 0.00                            | 0.00                  | 8,815,649.05            | 0.00        | 8,815,649.05                           |
| <b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>81,346,141.00</b>            | <b>62,581,247.76</b>  | <b>1,128,911,406.54</b> | <b>0.00</b> | <b>1,272,838,795.30</b>                |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Өмнөх оны             |                | Тайлант оны           |                |
|-----------------------|--|-----------------------|----------------|-----------------------|----------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | 235,544,000.00        | 235,544,000.00 | 287,626,800.00        | 277,074,570.10 |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 235,544,000.00        | 235,544,000.00 | 287,626,800.00        | 277,074,570.10 |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 235,544,000.00        | 235,544,000.00 | 287,626,800.00        | 277,074,570.10 |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 152,111,700.00        | 152,111,700.00 | 198,471,800.00        | 198,395,161.70 |
| 210101                | Үндсэн цалин   | 125,628,000.00        | 125,628,000.00 | 143,165,100.00        | 143,285,100.00 |
| 210102                | Нэмэгдэл   | 12,245,600.00         | 12,245,600.00  | 41,054,000.00         | 40,894,252.63  |
| 210104                | Урамшуулал   | 14,238,100.00         | 14,238,100.00  | 14,252,700.00         | 14,215,809.07  |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 19,014,000.00         | 19,014,000.00  | 24,809,000.00         | 24,809,000.00  |
| 210201                | Тэтгэврийн даатгал   | 12,929,800.00         | 12,929,800.00  | 16,870,200.00         | 16,870,200.00  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал   | 1,520,900.00          | 1,520,900.00   | 1,984,700.00          | 1,984,700.00   |
| 210203                | ҮОМШО-ний даатгал  | 1,217,000.00          | 1,217,000.00   | 1,587,800.00          | 1,587,800.00   |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал   | 304,000.00            | 304,000.00     | 396,900.00            | 396,900.00     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал  | 3,042,300.00          | 3,042,300.00   | 3,969,400.00          | 3,969,400.00   |
| <b>2103</b>           | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 18,078,000.00         | 18,078,000.00  | 25,669,400.00         | 25,668,700.40  |
| 210301                | Гэрэл, цахилгаан   | 3,283,000.00          | 4,413,925.00   | 3,611,200.00          | 3,611,200.40   |
| 210302                | Түлш, халаалт  | 13,125,000.00         | 11,996,375.00  | 21,477,500.00         | 21,476,800.00  |
| 210303                | Цэвэр, бохир ус  | 1,670,000.00          | 1,667,700.00   | 580,700.00            | 580,700.00     |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 2,393,100.00          | 2,393,100.00   | 6,556,800.00          | 5,773,200.00   |
| 210401                | Бичиг хэрэг  | 440,400.00            | 611,900.00     | 1,150,000.00          | 1,149,900.00   |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 657,600.00            | 657,600.00     | 650,000.00            | 650,000.00     |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 480,000.00            | 426,800.00     | 1,296,800.00          | 1,296,800.00   |
| 210404                | Ном, хэвлэл  | 200,000.00            | 88,100.00      | 300,000.00            | 300,000.00     |
| 210406                | Бага үнэтэй, гүргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 615,100.00            | 608,700.00     | 3,160,000.00          | 2,376,500.00   |
| <b>2105</b>           | <b>Нормативт зардал</b>  | 35,679,400.00         | 37,477,822.00  | 28,478,300.00         | 19,381,608.00  |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 200,000.00            | 2,000,000.00   | 1,750,000.00          | 1,750,000.00   |
| 210502                | Хоол, хүнс   | 34,807,400.00         | 34,805,822.00  | 26,728,300.00         | 17,631,608.00  |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 7,222,000.00          | 7,222,000.00   | 1,544,800.00          | 1,000,000.00   |
| 210604                | Урсгал засвар  | 7,222,000.00          | 7,222,000.00   | 1,544,800.00          | 1,000,000.00   |
| <b>2107</b>           | <b>Томилголт, зочны зардал</b>                                       | 300,600.00            | 300,600.00     | 800,000.00            | 800,000.00     |
| 210702                | Дотоод албан томилголт   | 300,600.00            | 300,600.00     | 800,000.00            | 800,000.00     |
| <b>2108</b>           | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 410,000.00            | 410,000.00     | 346,700.00            | 296,900.00     |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 230,000.00            | 230,000.00     | 166,700.00            | 116,900.00     |
| 210802                | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 180,000.00            | 180,000.00     | 180,000.00            | 180,000.00     |
| <b>2109</b>           | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 335,200.00            | 335,200.00     | 950,000.00            | 950,000.00     |
| 210902                | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 335,200.00            | 335,200.00     | 950,000.00            | 950,000.00     |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 235,544,000.00        | 235,544,000.00 | 287,626,800.00        | 297,780,342.00 |
| <b>1310</b>           | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | 235,544,000.00        | 235,544,000.00 | 287,626,800.00        | 297,780,342.00 |
| 131007                | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                             | 235,544,000.00        | 235,544,000.00 | 287,626,800.00        | 297,780,342.00 |



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх он | Гүйцэтгэл           |
|-------------|---|----------|---------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>          | -        | <b>1,640,000.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                              | -        | <b>1,640,000.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>            | -        | 1,640,000.00        |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>           | -        | 1,640,000.00        |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс       | -        | 1,640,000.00        |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)</b>        |          |                     |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -        | -                   |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -        | -                   |



### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг М.Баярмагнай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилтой ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 331,783.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 6,636.0 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,389.1 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт       |
|---|--------------------|--------------------|----------------|
| Б   | 1                  | 2                  | 3=2-1          |
| Авлага  | 153.2              | 573.4              | 420.2          |
| Бараа материал                                    | 35,349.4           | 40,353.3           | 5,003.9        |
| Үндсэн хөрөнгө                                    | 1,339,520.7        | 1,380,643.4        | 41,122.7       |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл                          | -111,000.3         | -148,157.9         | 37,157.6       |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>1,264,023.1</b> | <b>1,273,412.2</b> | <b>9,389.1</b> |
| Өр төлбөр   | -                  | 573.4              | 573.4          |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 81,346.1           | 81,346.1           | -              |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>1,264,023.1</b> | <b>1,273,412.2</b> | <b>9,389.1</b> |

Авлагын үлдэгдэл 573.4 мянган төгрөг болж 420.2 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбоотой авлагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,353.3 мянган төгрөг болж 5,003.9 мянган төгрөгөөр өссөн нь 49,580.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 44,576.1 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,380,643.4 мянган төгрөг болж 41,122.7 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн худалдан авалттай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 573.4 мянган төгрөг байгаа нь хувь хүнд өгөх өглөгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Хөлөнбуйр санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 126,387.6 мянган төгрөгөөр буюу 59.0 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 55,371.6 мянган төгрөгөөр буюу 20.0 хувиар өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 287,626.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 287,626.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 297,780.3 мянган төгрөг болж 10,153.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 297,780.3 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 297,780.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 297,780.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 277,074.6 мянган төгрөгийг зарцуулж 20,705.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 277,074.6 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байна. Үүнээс цалин,нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 223,204.2 мянган төгрөг буюу нийт зардлын 80.6 хувийг эзэлж байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт үйл ажиллагаанаас 1,640.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Нэмэлт үйл ажиллагааны зардлаас 1,640.0 мянган төгрөгийг бараа материал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд зарцуулсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 142 мэдээлэл оруулснаас хугацаандаа оруулсан 121 мэдээлэл, хугацаа хоцорч 21 мэдээлэл оруулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Батлагдсан төсөв гүйцэтгэл хэтрэлт хэмнэлтийн шалтгаан 543,805.5 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж биелүүлж ажилласан байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,401,437.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,401,437.5 мянган төгрөгийн зөрчилд 332.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,401,104.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 1,401,437.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,401,437.5 мянган төгрөгийн зөрчилд 332.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,401,104.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-н 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 332.8 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн

тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

- Худалдан авалтын үнийн гэрээний үнэ болон тендерийн үнийн саналтай харьцуулахад 15,808.7 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлсийн 2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

- Тайлант оны эцэст 1,380,543.3 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг хангалтгүй чанаргүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

- Тайлант хугацаанд гарсан зардлаас 4,752.7 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

|                              |   |  |                    |
|------------------------------|---|--|--------------------|
| Огноо:                       | Аудитын нэр:                            | <i>Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Цэцэрлэг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i> | Аудитын код:       |
| 2020.02.25                   |   |  | ДОА-2021/8/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Цэцэрлэг |  | Мянган төгрөг      |

| № | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн  | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                              |
|---|--|-------------|---------------------------------------|---|------------------------------|
|   |  |             | Нэр                                   | Албан тушаал                                      | Овог нэр                     |
|   | 1  | 2           | 3                                     | 4   | 5                            |
| 1 | Хөрөнгө, бараа материалын тооллогын баримт ирүүлээгүй. 1,380,543.3 мянган төгрөгийн хөрөнгө тоолоогүй. Бараа материалын дансанд 10,525.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 329.0 мянган ном хольж бүртгэсэн.   | 1,380,543.3 | Албан шаардлага өгөх                  | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч                | М.Баярмагнай<br>Б.Тананцэцэг |
| 2 | Нийт 121 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба 21 мэдээллийг хугацаа хоцорч оруулсан байна. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр) Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, | 0.0         | Албан шаардлага өгөх                  | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч                | М.Баярмагнай<br>Б.Тананцэцэг |

|            |   |                    |                       |                                    |                              |
|------------|---|--------------------|-----------------------|------------------------------------|------------------------------|
|            | өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр) |                    |                       |                                    |                              |
| 3          | Тэнгэр тэтгэх тал ХХК-тай хийсэн Нүүрс нийлүүлэлт гэрээ байхгүй. 483.5 тн нүүрс үнийн хэлбэлзэлтэй авсан. Бараа материалд орлогоор бүртгэж зарцуулсан. Хүнсний бүтээгдэхүүний 15,808.7 мянган төгрөгийн худалдан авалтыг иргэн Чулуунбат, Хашчулуун, Дорнод гурил ХХК, Тэгш 5 хан ХХК -аас хийсэн бөгөөд гэрээ байгуулаагүй байна.  | 15,808.7           | Албан шаардлага өгөх  | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч | М.Баярмагнай<br>Б.Тананцэцэг |
| 4          | Харилцахаас 45,521.2 мянган төгрөгийн зардал гарсан ба төлбөрийн цахим системд илгээгдсэн баримттай тулгахад 4,752.7 мянган төгрөгийн баримт илгээгдээгүй байна.  | 4,752.7            | Албан шаардлага өгөх  | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч | М.Баярмагнай<br>Б.Тананцэцэг |
| 5          | Батлагдсан төсөв 650.0 мянган төгрөг ба батлагдсан төсвөөс зарцуулалт хэтрээгүй жишиг нормоор тооцооход 332.8 мянган төгрөгийн илүү зарцуулалтай байна.   | 332.8              | Төлбөрийн акт тогтоох | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч | М.Баярмагнай<br>Б.Тананцэцэг |
| <b>ДҮН</b> |   | <b>1,401,437.5</b> |                       |                                    |                              |